

**“ГОВЬ” ХЭМЭЭХ НЭРИЙН ТУХАЙ**

Г.Гэрэлмаа

Монгол орон газарзүйн байрлалын хувьд ойт хээр, хээр, говь, цөлийн гэсэн дөрвөн бүсийг дамжин оршдог агаад ерөнхийдөө говь нь нийт нутгийн гуравны нэг хувийг эзлэн оршдог. Иймээс монголчуудын танин мэдэх сэтгэлгээ, улмаар үгийн санд “говь” хэмээх үг өөрийн байраа баттай эзэлжээ.

Үгсийн сангийн бүрэлдэхүүн нь хүний танин мэдэхүй хийгээд нийгэм-эдийн засгийн хөгжлийн олон үе шатыг дамжин бүрэлдэж ирсний дээр, нийгэм, нийгмийн тодорхой бүлэг хийгээд хувь хүний харилцааны олон талт үүргийг гүйцэтгэдэг тул<sup>1</sup> түүний нэгж болсон үг мөн адил олон талт үүрэгтэй болдог нь тодорхой юм. Энэ нь үгийн сангийн дотоод холбоо харилцаатай нягт хамааралтай учир энэхүү мөн чанарыг нэг үгийн хүрээнд нарийвчлан судлахын үүднээс “говь” хэмээх үгийн гарал үүсэл, үгийн сангийн үндсэн утга болон оноосон нэрийн утга, нэр томъёоны үүргийн талаар авч үзэхийг зорив.

***а. “Говь” хэмээх үгийн гарал үүслийн тухай***

Аливаа үгийн гарал, үүслийг судлах нь тухайн үгийг уугуул үг мөн эсэхийг шалгах томоохон шалгуур байдаг.

“Говь” хэмээх үгийн гарал үүслийг хөөхийн тулд монгол төрөл хэлнүүд цаашлаад Алтайн язгуурын хэлнүүдийн баримтаас хайх нь зүйтэй байна.

Монгол бичгийн хэлэнд говь хэмээх нь *ɣobil* 1, *ɣobi*, *ɣobija* 2 (L 357) гэсэн хэлбэртэй агаад ийм хэлбэрээр Дунсян хэлэнд *gobi*, Шар-уйгар хэлэнд *gobi*, Дагуур хэлэнд *gobi*, *gob* (Тод. Даг. 132) хэлэнд бараг авианы хувиралгүй тэмдэглэгдсэн нь монгол төрөл хэлнүүдэд нийтлэг үг болох нь харагдаж байна. Харин Бао-ань хэлэнд эгшиг урагшилсан хэлбэрээр *gəbi* гэж тохиолдоно. Цаашлаад Халимаг хэлэнд *ɣowl* 1, *ɣuw*, *ɣowə*, *ɣowə*, *ɣowi* 2 КРС 164, Ордос хэлэнд *Guwil*, *Guwi* гэж о эгшиг уруулын шинжээрээ давамгайлсан хэлбэртэй байна.

Монгол бичгийн хэлний *ɣobi* (говь, говил, гувил)-ийг өвөг Алтайн хэлнээс сурвалжлахад Өвөг Алтай хэлэнд \**guru*, өвөг монгол хэлэнд \**gobi*, өвөг Тунгус-Манж хэлэнд \**gub*<sup>2</sup>-, Түрэг хэлэнд \**kobuk*<sup>3</sup> гэсэн хэлбэртэй байна. Үүнийг Алтайн хэлний гийгүүлэгчийн тохирлын үүднээс үзвэл Монгол, Манж- тунгус хэлний урдуурх эгшигтэй үгийн бүтцэд тохиолдох \**g* нь Чуваш болон Түрэг хэлний \**k*-тэй тохирдог<sup>4</sup> агаад утга нь 1. Ганга, гуу (жалга), 2. хүнгүй газар, 3. цөл газарыг хэлнэ гэжээ. Энэ баримт дээр халхын *govil* 1, *gov*, буриадын *gobil*, *gubi*<sup>5</sup> гэсэн хэлбэрийг нэмээд харьцуулан *g* болон *x*-ийн аман аялгууны сэлгэцээс үзэхэд говил, ховил гэж сэлгэн хэлэлцэх тул, говь хэмээх үг нь ховил, говил гэсэн үгээс үүсэлтэй аж. Үүнийг халимаг хэлэнд байх новль- 3. Низкая местность (Муниев Б.Д, 1967) гэсэн үг баталж байна.

<sup>1</sup> Орчин цагийн монгол хэлний үгсийн сангийн судлалын үндэс. Уб., 1985, х.31

<sup>2</sup> Altaic etymology.starling.rinet.ru.

<sup>3</sup> Starostin.S, Dubo.A, Mudrak.O., Etymological dictionary of Altaic languages.Vol.8-1, Brill., 2003,c.710

<sup>4</sup> Поппе.Н.Н., Алтайн хэл шинжлэлийн удиртгал. Уб., 1999, х.260

<sup>5</sup> Altaic etymology.starling.rinet.ru.

**Г.Гэрэлмаа**

ШУА-ийн Хэл, зохиолын хүрээлэн  
g\_mgl2003@yahoo.com

**С.Чулуун, Э.Равдан, Х.Фүтаки, А.Камимүра**

Монголын газрын зураг, газрын нэр судлал

“Адмон принт” ХХК хэвлэлийн газар. Улаанбаатар, 2015, ISBN 978-99973-0-702-6

**б. Монгол хэлний үгийн санд дахь “говь”**

Говь хэмээх нь монгол хэлний үгийн сангийн уугуул үг тул үндсэн болон шилжсэн утгаар хэрэглэгдэнэ. Үүнийг “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь”-д “Ургамал тачир сийрэг, ой мод ба урсгал ус маш ховор, элс хайрга хөрстэй, тарвага нутагшидаггүй, хээр тал газар”<sup>6</sup> хэмээн тодорхойлжээ.

Харин “Монголын үндэсний нэвтэрхий толь”-д “Монгол улсын өмнөд, зүүн өмнөд, Өвөрмонголын баруун, Төвдийн хойт, Шинжаан Уйгарын хойд хэсэгт оридог байгалийн нийтлэг нэг төрх бүхий цөл, цөлөрхөг нутгийн нэр. Говийн муж нь 900-1200 м өргөгдсөн талархаг гадаргатай, гандуу уур амьсгалд зохицсон сийрэг ургамалтай, эртний үлдэгдэл уул нурууд нэлээд тохиолдох бөгөөд тэдгээр нь чулуурхаг хөрстэй, нүцгэн уулын хэв шинжтэй байдаг. Говь нь далай тэнгисээс алс эргэн тойрон өндөр уулсаар хүрээлэгдсэн хотгор учир эх газрын эрс тэс уур амьсгалтай. Гадаргын харьцах өндрийн зөрөө ихтэй учраас уур амьсгалын хэлбэлзэл их байдаг. 1-р сарын дундаж температур  $-40^{\circ}\text{C}$ , 7-р сарынх нь  $45-50^{\circ}\text{C}$ . Хоногийн температурын зөрөө өдрийн их халалтаас хамаарч  $30-40^{\circ}\text{C}$  хүрэх ч тохиолддог. Жилд 50-200 мм тундас унадаг. Хур тундас нь улирлаар жигд биш, ихэнх нь дулааны улиралд буудаг. Хавар намартаа бүтэн сараар ч хур тундас орохгүй жил байдаг. Тачир сийрэг ургамлын бүрхэвчтэй. Төрөл зүйл нь цөөн. Гандуу нөхцөлд зохицсон урт үндэстэй, титэм багатай сийрэг. Зарим нутагт ус булаг бүхий баян бүрдтэй. Уур амьсгал, хөрс, ургамлын нөхцөлдөө зохицсон нэн өвөрмөц амьтны аймагтай. Хулан, тахь, аргаль, янгир, ирвэс, мазаалай, хар сүүлт, цагаан зээр, төрөл бүрийн мөлхөгчид гэх зэрэг дэлхийд ховор амьтад олонтой. Говийн хуурай уур амьсгалд зохицсон заг, хайлаас, сухай, зэрэг мод, сайр, хөндий дагаж ургасан байдаг. Говьд мал аж ахуй нэлээд хөгжснөөс дэлхийн хоёр бөхтэй тэмээний 80% нь байдаг. Хүн амын нягтшил бага, том хот, суурин цөөн байдаг нийтлэг онцлогтой”<sup>7</sup> гэсэн нь олон нийтэд зориулсан говийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэлтэй тодорхойлолт болно.

Үгийн сангийн үүднээс үзвэл говь хэмээх үг бусад үгтэй хоршиж **ГОВЬ ЦӨЛ** (ургамал тачир сийрэг, усгүй шахам хээр тал газар ба байнгын хуурай амьсгалтай байгалийн бүс) ойролцоо утга заадаг бол **хангай говь** (уул ус жигдэрсэн газар болон тал хээр бүхий элс зонхилох газар)-эсрэг утга заана. Хангай нь ус ургамал жигдэрсэн мал хүний амьдрах таатай орчин бол говь нь ус ургамал багатай хатуу ширүүн уур амьсгалтай хүн ам сийрэг суудаг нутаг учир эсрэгцүүлсэн утгатай хоршоо үг үүсчээ.

Говь хэмээх үгийн язгуурт дагавар залган бүтээсэн **говьдуу** хэмээх үг говийн шинж давамгай газрыг хэлдэг бол, **говьших** хэмээх үг нь говийн шинжтэй болох гэсэн утга илтгэдэг, харин **говилох** гэдгээр малаа хужир мараанд оруулахыг хэлэх жишээтэй. Түүнчлэн хангайн бүсэд суугчид “**шүдлэн говь**” хэмээн хэлэлцэх бөгөөд энэ нь уул нь модгүй, урсгал усгүй хэрнээ хангайн бүсэд орших газрыг хэлдэг юм. Харин говийн бүсэд оршин суугчид “зүүн говь, баруун говь” хэмээн хэлэлцэх агаад энэхүү говь гэж нэрлээд буй газрыг нь ажиглавал, хөндий, хоолой, бут бударганатай, зөөлөн хөрст нам газраа нэрлэдэг байх юм. Ингэхээр бидний ерөнхий нэрлэсэн говь хэмээх ойлголтын дотор тусгай говь гэдэг ухагдахуун байдаг нь илэрхий байна. Иймээс “говь” хэмээх оноосон нэртэй олон газар бий болох үндэс болжээ гэж үзэж болмоор байна.

**в. Оноосон нэрийн үүрэгтэй “говь”**

Монгол хэлний үгийн сангийн үндсэн бүрэлдэхүүний нэг болсон **ГОВЬ** хэмээх үг оноосон нэрийн үүргээр орж буй нь судлаачдын үзсэнээр нэрийтгэл нэрээс оноосон нэр үүсч<sup>8</sup> байгаа үзэгдэл юм. Бодит ертөнцийн юм үзэгдлийг заан нэрлэсэн нэрийг төрлийн олон юмнаас ялгахын тулд нэг зүйлд тусгайлан өгсөн нэр буюу оноосон нэр болгосон хэрэг билээ.

“Говь” хэмээх үг оноосон нэрийн үүрэг гүйцэтгэхдээ дараах хоёр хэлбэрээр тохиолдоно. Үүнд:

<sup>6</sup> Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. Уб., 2008, А-Г, х.502

<sup>7</sup> Монголын үндэсний нэвтэрхий толь. I, А-З, Уб., 2009, х.381

<sup>8</sup> Сэржээ.Ж., Орчин цагийн монгол хэлний оноосон нэрийн судалгаа. Уб., 2010, х.11

1. “Говь” өөрөө оноосон нэр болно. Тухайлбал, “*Говь*” ХХК ноолуурын үйлдвэрийн оноосон нэр, “*Алтан говь*” ХХК – жуулчны бааз, мөн шар айрагны нэр, *Говийн гүрвэл, говийн зулман хуруут, говийн шар*<sup>9</sup>, *Ursus gobiensis*-мазаалай-говийн баавгай-Gobi bear-гобийский медведь, *Allactaga bullata*-говийн алаг даага зэрэг амьтны нэр, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Говьсүмбэр аймаг, Мандалговь хот, Говь-Угтаал сум зэрэг засаг захиргааны нэгжийн нэр оноосон нэрийн үүргээр оржээ. Цаашилбал,

Говийн булаг - Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт 960м өндөрт байдаг нуур,

Говийн тойром - Сүхбаатарын Эрдэнэцагаанд

Говийн төхөм - Өмнөговийн Манлай суманд

Говийн улаан нуур - Дорноговийн Их хэт суманд

Говийн худаг - Сүхбаатар Түвшинширээ, Баяндэлгэр, сумлын нутгийн заагаар Улаан худгаас Хуримын нуур хүртэлх 60-аад км үргэжилдэг нуур, тойром, хужир мараа бүхий хотгор

Говийн ганга - Гангийн зүйлийн эмт ургамал. Хижиг ханиад халуун суулга намдаах, шарх эмчлэх, үнэртэн утлага хийхэд ордог олон наст өвс.

Говь-Алтай омгийн хонь - ноос ихтэй

Говь гурван сайхан үүлдрийн ямаа - ноолуур чиглэлийн ямаа говиор тархсан.

Говийн их дархан газар - Алтай нурууны өвөрт оршино.

Говийн бага дархан газар Өмнөговийн Номгон Баян-Овоо, Ханбогд, Дорноговийн Хатанбулгийн өмнөд хэсэгт оршино.

Говь-Алтайн нуруу-монгол Алтайн нурууны үргэлжлэл (Нэвтэрхий толь х.381-382) гэх зэргээр нийлмэл бүтэцтэй оноосон нэр бүтээсэн нь элбэг байна.

2. Оноосон нэрийн, ялангуяа нийлмэл бүтэцтэй оноосон нэрийн бүрэлдэхүүнд орж суурь буюу дэвсгэр нэрийн үүргээр “говь” гэдэг үг элбэг тохиолдож байна.

Эрдэмтэн Э.Равдангийн “Монголын газар усны нэрийн зүйлчилсэн тайлбар толь”-д Авдарын говиос эхлээд Яхийн говь хүртэл – 372 говийн нэртэй газар усны нэр<sup>10</sup> тохиолдож байгаа бөгөөд ерийн нэр дэвсгэр нэрийн үүргээр хэрэглэгддэг талаар эрдэмтэн Э.Равдан, Ж.Сэржээ нар нарийвчлан судалсан. Энэ дэвсгэр нэрийн үүрэгтэй оноосон нэрийг эрдэмтэн Тү.Баасан “Монголын говь” хэмээх бүтээлдээ судалж, Монголын говийг жагсаан ямар аймгийн ямар суманд орших хийгээд аймаг бүрд байх говь нэртэй газрыг тооцоолон, Дундговь аймагт 94, Дорноговь аймагт 93, Сүхбаатар аймагт 70, Дорнод аймагт 29, Говь-Алтай аймагт 21, Ховд аймагт 8, Хэнтий аймагт 8, Баянхонгор аймагт 5, Баян-Өлгий аймагт 5, Увс аймагт 3, Өвөрхангай аймагт 3, Төв аймагт 2 говь бий<sup>11</sup> гэсэн нь нийтдээ 341 говийг тэмдэглэн газарзүйн аль бүсэд байх болон говийн хэмжээ, ургах ургамал, амьдрах араатан жигүүртэнг хүртэл товч танилцуулсан юм. Энд дурдагдсан оноосон нэрийн бүрэлдэхүүн гол төлөв хоёр, гурван үгээс бүтсэн тухайлбал, *Борогчингийн говь, Сэвхүүлийн говь, Зуун модны говь, Цагаан хөөврийн говь* зэргээр оноосон нэрийн бүтцэд орж тухайн оноосон нэрийг тодруулах үүргээр “говь” нь хэрэглэгджээ.

### ***г.Нэр томьёоны үүрэгтэй “говь”***

Аливаа хэлний үгийн сангийн үндсэн үг тухайн салбар шинжлэх ухаанд нэгж үүрэгтэй болж нэр томьёо болно. Үүний нэгэн жишээ нь говь хэмээх үг агаад газар зүйн салбарт нэр томьёоны үүргээр хэрэглэнэ.

Анх Оросын газарзүйч А.Ф.Гумбольдт 1829 оны орчимд Урал, Алтай, Каспийн хавиар аялж, улмаар “Центральная Азия” нэртэй бүтээлийг 1843 онд хэвлүүлсэн. Үүнд **Гоби**-гэдгийг газар зүйн ухаанд нэр томьёоны үүргээр анх хэрэглэж улмаар Төв Ази бол “Говь” юм гэсэн санааг дэвшүүлжээ.

<sup>9</sup> Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. А-Г, Уб., 2008, х.503

<sup>10</sup> Равдан. Э., Монгол газар нутгийн нэрийн зүйлчилсэн толь” Уб., II 2004, х.146-152

<sup>11</sup> Баасан.Тү., Монголын говь. Уб., 2010, х.113-130

Удалгүй Монгол оронд 1922-1925 оны хооронд 4 удаа ажилласан Андрусийн экспедицийн бүрэлдэхүүн орж ажилласан Ч.Беркей, Ф.Моррис нар “Монголын геологи” хэмээх бүтээлийг 1927 онд Нью-Йорк хотноо хэвлүүлсэн агаад түүнд Говь гэдгийг “Төв Азийн өндөрлөгийн өргөн уудам нутгийн эзлэн орших гүехэн устай, хурдас бүхий ай савуудыг багтаасан хотгор газар”<sup>12</sup> хэмээн газар зүйн үүднээс анх тодорхойлоод энэ говийн дотор олон бассейн буюу ай сав байгааг тэмдэглэсэн юм. Ингэснээр шинжлэх ухаанд говь-гоби хэмээх нэр томъёог оруулжээ хэмээн үзэж болох юм. Үүнээс хойш говь хэмээх үгийг англи хэлний цөл гэдэг үгтэй хоршиж Gobi desert хэмээн нэрлэлт бий болж, *Алтайн нуруунаас эхлээд Монголын өмнө хэсгийн талархаг нутаг, баруун тийшээ Такламаханы цөл, хятадын хойд хэсэг, Гансу муж хүртэлх Төв Азийн өргөн уудам нутгийг эзлэн оршдог цөлийн муж*<sup>13</sup> гэсэн ойлголтоор дэлхий дахинаа түгжээ.

Монголчууд “говь” гэдэг нэр томъёог хэрхэн ойлгож буйг авч үзвэл Gobi-(Монгол) - говь (Чулуурхаг болон давсархаг хөрстэй, тачир сийрэг ургамалтай, талархаг, ухаа гүвээрхэг нутаг газрын ерөнхий нэр)- gobi (равнина или увалистая местность покрытая редкой растительностью с каменной или засоленной почвой)<sup>14</sup> гэсэн “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар” толийн тайлбараас зөрүүгүй байгаа нь жинхэнэ нэр томъёо үүргээр ухагдахууныг нь тайлбарлаагүй гэсэн үг юм.

Дүгнэлт:

1. Говь хэмээх нь монгол хэлний уугуул үг гэдгийг Өвөг Монгол хэлний болон монгол төрөл хэлний баримтаас харж болох бөгөөд ховил, говил гэдэг үгээс гаралтай байна.

2. Говь нь монгол хэлний үгийн санд үндсэн утгаараа байхаас гадна оноосон нэрийн үүргээр хэрэглэгдэж байна.

3. Говь хэмээх үг нь газарзүйн шинжлэх ухааны нэршил болж gobi desert гэсэн хэлбэрээр англи болон бусад хэлэнд тархжээ

## НОМЗҮЙ

### а. Судалгааны бүтээл

1. Баасан Тү., Монголын говь. Уб., 2010, 288х.
2. А.Ф.Гумбольдт. Центральная Азия. М., 1843, 661с.
3. Charles P. Berkey, Frederick K.Morris Geology of Mongolia. - Natural History of Centrel Asia. Vol. II. 457р.
4. Догсүрэн.Ч., Монгол газар усны нэрийн тогтолцооны зарим асуудалд. - Studia Mongolica, №2, Уб., 1975, х.243-251
5. Лувсандэндэв. А., Сүрэнхүү Л., Газар зүйн оноосон нэр бичих дүрэм. Уб., 1982, -УНТКМ №119.
6. Лувсандэндэв А., Монгол орны газар нутгийн түвд нэрийн учир. -Хэлбичгийн ухааны зарим асуудал. №2, Уб., 1980, х.146-150, -Хэл зохиол судлал, №17, Уб., 1986, х.3-8
7. Лувсандэндэв. А., Гадаад үг хэрхэн бичих тухай асуудалд. -Монгол хэл бичгийн зарим асуудалд. Уб., 1959, х.68-75.
8. Монгол орны газрын зураг болон газар нутгийн нэрийн судалгааны асуудлууд. Уб., 2012, 135х.
9. Нэр судлал. №1, Уб., 2003, 198х.
10. Пүрэв-Очир Б., Монгол хэлний “бэлчир” хийгээд “бэлчирлүүлэхүй” гэдэг үгийг утга, соёл, хэрэглээний талаас шинжлэхүй. - “Монгол судлал”, МИУС, МХСС-ийн ЭШБ, Уб., 2009, Б.30, (318), х.100-107
11. Равдан.Э., Монгол газар нутгийн нэрийг судлах онолын суурь зарчмууд.-МУИС-ийн ГХСС-ийн ЭШБ, №283/11/, Уб., 2007,

<sup>12</sup> Ч.Берки, Ф.Моррис. Geology of Mongolia, N-Y., 1927. p.9

<sup>13</sup> En.wikipedia.org/wiki.Gobi.desert

<sup>14</sup> Баасан.Тү, Нямдолгор.В., Говь цөлийн нэр томъёоны англи-монгол-орос толь. Уб., 2006, х.58,

**б. Толь бичиг**

12. Баасан Тү., Нямдолгор В., Говь цөлийн нэр томъёоны англи-монгол-орос толь. Уб., 2006, 140х.
13. Бурятско-русский словарь. Сост. Чермисов К.М., М., 1973,
14. Калмыцко-русский словарь. Под ред. Б.Д.Муниев, М., 1977, 764с.
15. Газар зүйн нэр томъёоны орос-монгол толь бичиг., Уб, 1986, -256х
16. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. Уб., 2008, 5 боть,
17. Монголын газар усны нэрийн зүйлчилсэн толь. Эмх.Э.Равдан, 5 боть, 2004-2006.
18. Монгол газар усны нэр томъёо.Уб., 1982, УНТКМ №119, Болов. Ч.Догсүрэн, П.Хосбаяр. -62х.
19. Радлов В.В. Опыт словаря тюркских наречия. Т.II, часть 2, С.Пб.,1899,
20. Словарь общегеографических терминов. Ed., L.D.Stamp, М., 1975, 2т,
21. Starostin.S, Dubo.A, Mudrak.O., Etymological dictionary of Altaic languages. Vol.8-1, 8-2, 8-3, Brill., 2003,
22. Шагдар Ш., Монгол орны газар зүйн нэрийн товч толь бичиг. Уб., 2 хэвлэл 1978, 2000.

*Дэлхийн газрын гадаргын зурагт тэмдэглэгдсэн Говийн байршил*



**SUMMARY**

The geographical location of Mongolia stretches through four zones as forested steppe, steppe, gobi and desert. The gobi covers one third of the territory. That’s why the word ‘gobi’ has a deep-seated inference in cognition of Mongolians and stands for the base vocabulary of the Mongolian language.

Since the vocabulary system of any language evolves and develops as reflection of many stages of the human cognition and socio-economic development and it plays multilateral roles in the society, social groups and individual communication. A word, the smallest element of a language has also multilateral roles. In the paper, we investigated the word ‘gobi’, its origin, its accepted meaning, the meaning of its proper name and its functional roles in the terminology.

Our investigation showed that the word ‘gobi’ is an original word of Mongolian language since it was originated from a word “ховил, говил”(groove).

Since the word ‘gobi’ is the original word of the Mongolian language, it has an accepted and a figurative meaning.

The word ‘gobi’, a basic component of the Mongolian language vocabulary, is also used as a proper name in the language.

The word ‘gobi’ is used as a term in the geography.